

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.04.22 № 03/2932

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан ТБ/20240102205 дугаартай “АТМ, ПОС, дугаар тараагч, киоскны цаас” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Оффис мэйт саплайер” ХХК болон “Эм ди даян” ХХК-аас тус тус гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Оффис мэйт саплайер” ХХК-ийн гомдолд тус компанийн тендерээс нийлүүлэх барааны дэлгэрэнгүй танилцуулга, зураг ирүүлээгүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй, мөн захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Грийн эко трейд” ХХК-ийн тендерт ирүүлсэн дээж шаардлагад нийцэхгүй болохыг Төрийн банкны КАЦБУАХ нэгжийн дүгнэлтээр тогтоосон буюу тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 17.4-т заасан шаардлага хангахгүй, “Эм ди даян” ХХК-ийн гомдолд тус компанийн тендерээс шалгарсан тохиолдолд барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээг баталгаат хугацаанд хийж гүйцэтгэхийг баталсан албан бичиг ирүүлээгүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй, мөн захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Грийн эко трейд” ХХК-ийн тендерт ирүүлсэн барааны дэлгэрэнгүй танилцуулгад Төрийн банкны лого байхгүй, цаасны дотоод голын тойрог 2.5 см эсэх тодорхойгүй, санал болгосон бараа техникийн тодорхойлолтын шаардлага хангахгүй, барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох баримт ирүүлээгүй, маягт 1-д тендер хүчинтэй байх хугацааг 30 хоногоор тогтоосон, маягт 3-т заасан гэрээний эхэлсэн/дууссан хугацааг зааж ирүүлээгүй нь шаардлага хангахгүй байх тул захиалагчийн шийдвэрийг хянан үзэхийг хүссэн байна.

I.Гомдолд дурдсаны дагуу “Оффис мэйт саплайер” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1.2-т “Нийлүүлэх барааны дэлгэрэнгүй танилцуулга, зураг ирүүлнэ.” гэж заасан байна.

“Оффис мэйт саплайер” ХХК тендерт нийлүүлэх барааны дэлгэрэнгүй танилцуулга, зургийг захиалагчийн техникийн тодорхойлолттой харьцуулсан хүснэгтээр бэлтгэн ирүүлсэн тул дээрх шаардлагад нийцэхгүй гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

9766005322

II. Гомдолд дурдсаны дагуу “Эм ди даян” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1.7-д “Тендерт шалгарсан тохиолдолд барааг нийлүүлсний дараах засвар үйлчилгээг баталгаат хугацаанд хийж гүйцэтгэхийг баталсан албан бичиг ирүүлнэ.” гэж заасан байна.

“Эм ди даян” ХХК тендерт ирүүлсэн 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А24-18 тоот албан бичигт “17. Баталгаат хугацаанд гарсан гэмтэл, доголдлыг туслан гүйцэтгэгч болон гуравдагч этгээдээр дамжуулахгүйгээр ажлын 3 хоногт багтаан өөрийн зардлаар шуурхай засварлах, арилгахыг зөвшөөрч буй батлан, зөвшөөрч хүргүүлж байна.” гэж дурдсан байх тул тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1.7-д заасан албан бичиг ирүүлээгүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

III. “Оффис мэйт саплайер” ХХК болон “Эм ди даян” ХХК-ийн гомдолд дурдсаны дагуу захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Грийн эко трейд” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 14.1-д “Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.” гэж заасан.

Худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр ирүүлсэн “Грийн эко трейд” ХХК-ийн тендер илгээх маягт (маягт 1)-ыг шалгахад тендер хүчинтэй байх хугацааг ажлын 70 өдрөөр тооцож ирүүлсэн байх тул энэ тухай “Эм ди даян” ХХК-ийн гомдол үндэслэлгүй байна.

2. “Грийн эко трейд” ХХК-ийн тендерийн маягт 3: “Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл”-ийн гэрээний эхэлсэн/дууссан хугацаа баганад хугацаанд нийлүүлсэн гэж бөглөсөн хэдий ч маягт 5: “Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл”-д гэрээ тус бүрийн эхэлсэн, дууссан огноог тусгаж ирүүлсэн байх тул маягт 3-д гэрээний эхэлсэн/дууссан хугацааг бөглөөгүй нь шаардлага хангахгүй гэх “Эм ди даян” ХХК-ийн гомдол үндэслэлгүй байна.

3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1.12-т “Тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг нийлүүлэхээр санал болгох тохиолдолд уг барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох нийлүүлэгч, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ болон тэдгээрээс энэ тухай гаргасан албан бичиг, борлуулалтын гэрчилгээг баталгаат орчуулгын товчоогоор орчуулуулж ирүүлнэ.” гэж заасан байна.

“Грийн эко трейд” ХХК тендерт “Сузоу шиандай цаас үйлдвэрлэл” компаниас олгосон 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл хүчинтэй байх бүрэн эрхий гэрчилгээ /үйлдвэрлэгчийн зөвшөөрөл/ ирүүлсэн байх тул тус гэрчилгээг ирүүлээгүй гэх “Эм ди даян” ХХК-ийн гомдол үндэслэлгүй байна.

4. “Грийн эко трейд” ХХК тендерт дээрх үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг “Мон тай син групп” баталгаат орчуулгын төвөөр орчуулуулж ирүүлсэн байх тул бүрэн эрхийн

гэрчилгээний доод мөрт /үйлдвэрлэгчийн зөвшөөрөл/ гэж эх албан бичигт байхгүй зүйлийг бичсэн гэх "Эм ди даян" ХХК-ийн гомдол үндэслэлгүй байна.

5.Тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолтод "АТМ-ын цаас: гадна диаметр 17 см, хар таслагчтай; ПОС-н цаас: цаасны хор нь Төрийн банкны логоны эсрэг талд байх, нийт урт 15 метрээс багагүй, цаасны чанар нь сайн /1-р зэргийн нимгэн байх/" гэж, худалдан авах ажиллагааны цахим системд оруулсан тодруулгад "1.АТМ-ын цаасны зузаан-80 gsm, 2.ПОС-ын цаас-48 gsm, 3. Киоск цаас-80 gsm, 4.Дугаар тараагчийн цаас-70 gsm" гэж тус тус заасан байна.

"Грийн эко трейд" ХХК-ийн тендерийн харьцуулсан техникийн тодорхойлолтод "1.АТМ-ын цаасны зузаан-80 gsm, 2.ПОС-ын цаас-48 gsm, 3. Киоск цаас-80 gsm, 4.Дугаар тараагчийн цаас-70 gsm" гэх үзүүлэлтийг тусгаж ирүүлээгүй байх тул тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолт шаардлага, өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 17.4-т заасанд нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

6.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 17.4-т "Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: Тийм. Тендер санал болгож буй бараа тус бүрээс 1 /нэг/ ширхэг загварыг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Холбоочдын гудамж, Төрийн банкны төв 2 дугаар байр, Худалдан авалтын үйл ажиллагааны хэлтэс, 2 дугаар давхар, 202 тоот өрөөнд /битүүмжилсэн сав, баглаа боодолтой, ялгаж таних тэмдэгтэй байх, жагсаалт хавсаргах/ ирүүлнэ. Загвар ирүүлээгүй, дутуу ирүүлсэн эсхүл ирүүлсэн загвар нь техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцээгүй тохиолдолд тус тендерээс татгалзах үндэслэл болно." гэж заасан байна.

Хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт зааснаар захиалагч хүлээн авсан загвар, дээжийг шалгах, турших үйл явцыг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулах үүрэгтэй.

Журмын 5.5-д "Сангийн яам хуулийн 48.4-т заасан тендер шалгаруулалтын хувийн хэргээс цахим системд байршуулаагүй баримт бичгийг цахимаар, эсхүл бичгээр ирүүлэхийг захиалагчаас шаардаж болно." гэж заасны дагуу дээрх дүгнэлтийг ирүүлэхийг захиалагчаас шаардсан боловч үнэлгээний хорооны дарга зөвшөөрөөгүй гэх үндэслэлээр ирүүлээгүй болохыг дурдах нь зүйтэй байна.


Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 17/1824, 17/1829, 17/1832 тоот шийдвэрийг тус тус хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.3 дахь заалтад үндэслэн тендер шалгаруулалтын тендерийн үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: "Оффис мэйт саплайер" ХХК, "Эм ди даян" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ